



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 0/20

Улаанбаатар хот

Зөвлөл байгуулах тухай

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 07-ны А/39 тоот захирамж, Сахилга дэг журам бэхжүүлэх, гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аяны ажлыг эрчимжүүлэх, зорилгоор ТУШААХ нь:

1. Тус төвийн албан хаагчид ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, иргэдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдыг шуурхай нягтлан шалгаж асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэн, эмч эмнэлэгийн ажилчдын сахилга дэг журам бэхжүүлэн зохицуулах зөвлөлийг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

- 1.Зөвлөлийн дарга: Ц.Тулга- Стратеги бодлого төлөвлөлт эрхэлсэн дарга
2.Нарийн бичиг: Н.Алтанзаяа-Хүний нөөцийн ажилтан
3.Гишүүдэд: Т.Гэрэлсүрэн-Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
Ц.Энхбаясгалан-Хүний нөөцийн албаны дарга
Д.Молор-Эрдэнэ- Поликлиникийн эрхлэгч
П.Тогтох-Эрдэнэ- Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч
Г.Оюунцэцэг- Яармаг салбарын эрхлэгч

2. Сахилга дэг журам бэхжүүлэн сайжруулах, гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аяны ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж тодорхой ажил зохион байгуулахыг зөвлөлийн дарга /Ц.Тулга/-д даалгасугай.

3.Ажлын хариуцлага сахилгыг өндөржүүлж архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, дотоод хяналт шалгалтыг сайжруулж байгууллага дээр хариуцлагатай эргүүл ажиллуулахыг хүний нөөцийн албаны дарга /Ц.Энхбаясгалан/-д үүрэг болгосугай.


4. Ажилчдын хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт сурталчилгааны ажлыг хуулийн зөвлөх /Г.Бадамханд/-тай хамтран зохион байгуулж ажиллахыг хүний нөөцийн албаны дарга /Ц.Энхбаясгалан/ нарт хариуцуулсугай.

5. Сахилга хариуцлага гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн талаар зохиосон ажлаа 14 хоног бүр эмч ажилчдад мэдээлж байхыг зөвлөлийн дарга /Ц.Тулга/-д үүрэг болгосугай.

6. Энэ тушаалын биелэлтийг улирал бүр тооцож, даргын зөвлөлийн хуралд оруулж танилцуулж байхыг Хүний нөөцийн албаны дарга /Ц.Энхбаясгалан/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.БОДЬЦЭЦЭГ



5 170 70 0149